

Эрх чөлөөний тугтай холбоотой орчин үеийн сургаалууд

“Бидний Бурханы дурсгалд”

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн ийн заасан.



Есүс Христийн талаар маш бага зүйл мэддэг хүмүүс энэ дэлхийд олон байдаг бөгөөд Түүний нэрийг олон зууны турш тунхаглаж байсан дэлхийн зарим хэсэгт Есүс Христэд итгэх итгэл буурч байна. . . .

Дэлхий ертөнц Есүс Христийн тухай бага ярих тусам бүгдээрээ Түүний тухай илүү их ярьцгаая. Түүний шавийн хувьд бидний жинхэнэ өнгө төрх илчлэгдэх тэр үед эргэн тойронд маань байгаа хүмүүсийн ихэнх нь биднийг сонсоход бэлэн байх болно. (Нийл

Л.Андэрсэн, “Бид Христийн тухай ярьдаг,” 2020 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 99)

“бидний шашны . . . дурсгалд”

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Даллин Х.Өүкс ийн заасан.



Бид ямар нэгэн шалтгаанаар өөрсдийн сүмд ач холбогдол өгөхөө боливол хувийн сүнслэг амьдралд маань аюул учрах бөгөөд Бурханаас өөрсдийгөө холдуулсан хүмүүсийн тоо манай улс үндэстнийг адислах Түүний адислалуудыг багасгана.

Сүмд явах, идэвхтэй байх нь бидэнд илүү сайн хүмүүс болж, бусдын амьдралд илүү сайн нөлөө үзүүлэхэд тусалдаг. Сүмд бид шашны зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлэх талаар заалгаж, бие биеэсээ суралцдаг. . . .

. . . Бурханы бүх бэлгийн хамгийн агуу нь болох мөнх амьдралыг эрэлхийлэхдээ Сүмийн эдгээр туршлагадаа тууштай байгаасай хэмээн би . . . залбирч байна. (Даллин Х.Өүкс, “Сүмд явах хэрэгцээ” 2021 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 18)

“Бидний эрх чөлөөний . . . дурсгалд”

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Роналд А.Расбанд ийн заасан.



Шашны эрх чөлөө гэж юу вэ?

Энэ бол бүхий л хэлбэрээр шүтэн бишрэх эрх чөлөө юм. Үүнд цуглан чуулах, үг хэлэх, хувийн итгэл үнэмшлийнхээ дагуу үйлдэх эрх чөлөө хамаарах бөгөөд бусад хүн ч мөн адил үйлдэх эрх чөлөөтэй. Шашны эрх чөлөө нь хүн бүрд юунд итгэхээ, итгэлийнхээ дагуу хэрхэн амьдарч, үйлдэхээ мөн Бурхан биднээс юу хүсэж байгааг өөрсдөө шийдэх боломжийг олгодог. . . .

Би та бүхнийг шашны эрх чөлөөний төлөө тэмцэхийг уриалж байна. Энэ нь Бурханы өгсөн сонгох эрх чөлөөний зарчмын илэрхийлэл юм.

Шашны эрх чөлөө нь өрсөлдөгч гүн ухааны эсрэг тэнцвэртэй байдлыг бий болгодог. Шашны сайн тал, хамрах хүрээ, урамшуулан дэмждэг өдөр тутмын хайрлах үйл хэрэг нь биднийг гол итгэл үнэмшлээ илэрхийлж, үүний дагуу үйлдэх эрх чөлөөгөө хамгаалах үед нэмэгддэг. (Роналд А.Расбанд, “Дэлхийг эдгээхийн тулд,” 2022 оны 5-р сарын Лиахона, 91)

“Бидний энх тайвны . . . дурсгалд”

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Жэффри Р.Холланд ийн заасан.



Бүх шархыг Эдгээгч, бүх бурууг зөвтгөгч Тэрээр биднээс дэлхийд өөр ямар ч аргаар олдохгүй амар тайвныг бүтээх хэцүү үүрэг даалгаврын төлөө Өөртэй нь хамт хөдөлмөрлөөсэй хэмээн хүсэж байна. . . .

. . . Амар тайвныг хайрлах, амар тайвныг эрэлхийлэх, амар тайвныг бүтээх, амар тайвныг цогцлоохыг буюу амар тайвныг тогтоогч байгаасай гэж би гуйж байна. Би энэ гуйлтаа Амар Амгалангийн Ханхүүгийн нэрээр хэлж байна. (Жэффри Р.Холланд, “Эвлэрлийн тохинуулал,” 2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 73)

“Бидний [гэр бүлүүдийн] . . . дурсгалд”

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч асан Бонни Л.Оскарсон ийн заасан.



Гэр бүлийн нөхцөл байдал ямар болох мөн хэдэн хүүхэдтэй гэдгээсээ үл хамааран хүн бүр гэр бүлийн тунхагт тайлбарласан Их Эзэний төлөвлөгөөний хамгаалагч нь байж чадна. Хэрэв энэ нь Их Эзэний төлөвлөгөө юм бол мөн бидний ч төлөвлөгөө байх ёстой! . . .

. . . Бүгд зоригтой зогсож, гэрлэлт, эцэг эх байх эрхийн, мөн гэр орныхоо хамгаалагчид нь байснаар Бурханы хаант улсыг байгуулахад гар бие оролцон тусалцгаая. Бид Их Эзэний төлөвлөгөөг хамгаалж, Түүний үнэнийг хойч үедээ зааж сургадаг, зоригтой, гуйвшгүй, бат дайчид нь байх ёстой. (Бонни Л.Оскарсон, “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид,” 2015 оны 4 сарын Ерөнхий чуулган, 134)